



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/649

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын 2 дахь хэсгийн 2.1.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжимт драмын театрын ерөнхий удирдаач Д.Насан-Очирын “Морин хуур-2020” наадмын шилдэг бүтээлийн уралдаанд оролцох зардлын дэмжлэгт 1000 000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт зарцуулагдах 1000 000 төгрөг /Нэг сая төгрөг/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ